



Title	Санаанаас гардаггүй сар жилүүд
Author(s)	Баттогтох, Раднаагийн
Citation	モンゴル研究. 2012, 27, p. 24-27
Version Type	VoR
URL	https://doi.org/10.18910/102379
rights	
Note	

The University of Osaka Institutional Knowledge Archive : OUKA

<https://ir.library.osaka-u.ac.jp/>

The University of Osaka

Санаанаас гардаггүй сар жилүүд

Раднаагийн Баттогтох

1973 онд МУИС-ийн Монгол хэлний ангид хот, хөдөө, гадаад дотоодын 32 оюутан элсэн орж байлаа. Биднийг хоёрдугаар ангид суралцаж байхад, зөвхөн ЗХУ-д бэлтгэдэг байсан япон хэлний мэргэжлийн хүмүүсийг дотооддоо бэлтгэх, шинэ залуу хүмүүсээр цус сэлбэх, Монгол-Японы ирээдүйн харилцааг урьдчилан харсан бодлогоор монгол хэлний ангийн оюутнуудаас япон, хятад хэлний группэд (одоогийнхоор бол сонгон) суралцах оюутнуудыг сонгон авч суралцуулах болсон билээ. Манай ангийнхан хоёрдахь элсэлт (1975 он) нь болж, япон хэлний группэд Т.Мөнхцэцэг, Ж.Оюунцэцэг, Д.Оюун, Ж.Энхтуяа, Д.Жаргал бидний 6 оюутан суралцахаар болж, Япон хэлний хичээлийг бидэнд манж хэл заадаг байсан Я.Шаарийбуу багш, Найрамдал нийгэмлэгийн ажилтан Алмааз, Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Жамбалсүрэн нар болон Токиогийн гадаад хэлний дээд сургуулийн багш Хасуми Харүо, Осакагийн гадаад хэлний дээд сургуулийн багш Онүки Масао, Васэда их сургуулийн багш Ёшида Жүничи нар зааж хэлд, хөлд оруулсан юм.

Говь-алтайн сонинд ажиллаж байгаад монгол хэлний ангид орсон намайг, төгсөөд нутагтаа ирнэ гэж хүлээж байсан аав, ээж рүүгээ “Япон хэл сурахаар боллоо” гэж утсаар ярихад “Очиж очиж самурайн хэл сураад байхдаа яадаг юм бэ, чи” гэж загнаж байсан нь зөвхөн манай хоёрын ч бодол биш, Японыг зөвхөн самурай гэж, тэр нь хачин түрэмгий хүмүүс байдаг гэсэн тэр үеийн нийтлэг ташаа ойлголт, нэр томъёог залруулахад энэ сургалт зохих ёсны хувь нэмэр оруулж, хоёр орны хоорондын харилцааны олон салбарт бид бүхэн, Их сургуулийн үе үеийн төгсөгчид өөр өөрийн үүргийг гүйцэтгэж яваад, үүнээс улбаалан бидний үр хүүхэд, ач, зээ нар минь хүртэл япон хэлийг сонирхон суралцаж, биднийг залгамжлаж байгаад их баярлаж, бас бахархаж явдаг юм.

Зөвхөн манай группынхнээс гэхэд, Мөнхцэцэг МУИС-ийн Гадаад хэл, соёлын сургуулийн тэргүүлэх профессор, доктор, Ж.Энхтуяа, “Green City” компаний захирал, Оюунцэцэг, яруу найрагч, олон хэлний орчуулагч, би гэдэг хүн Монголд Япон улсын оролцоотой байгуулагдсан “Говь”, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Ариун цэврийн цаасны “Долгион” үйлдвэр болон эрүүл мэнд, уул уурхай, барилга зэрэг бүхий л салбарт орчуулагч, сүүлийн үед япон хэлний багш, судлаачаар чадан ядан ажиллаж төгссөн сургууль, эрхэм багш нарынхаа чихийг халууцуулахгүйн төлөө хичээж явна. Гэхдээ, ямар нэгэн гадаад хэлийг төгс сурна гэж байдаггүй болов уу гэж сүүлийн үед улам ихээр бодох болжээ, ялангуяа япон хэл шиг тансаг атлаа, адармаатай хэлийг...

Тэр үед одоогийнх шиг олон төрлийн хичээл ч ордоггүй, сурах бичиг, гарын авлага ч байхгүй, толь бичиг бол бүр нүдний гэм байсан юм. Өдрийн хичээлд шинээр гарсан үг, ханз болгоноороо өөрөө өөртөө толь бичиг болгон хийж, өдөр бүр 50 үг цээжлэх үүрэг өөртөө өгч, мартсан үгээ маргаашийн тавин үгэн дээрээ нэмж цээжилдэг байж билээ. Хамгийн анхны толь бичгийг Онүки багш маань хэрэг болгон Японоос бидэнд авч ирж өгсөн нь Сансэйдо хэвлэлийн газраас эрхлэн гаргасан “Япон-Орос толь бичиг” байсан бөгөөд түүнийгээ өглөө, үдэшгүй эргүүлэн, бас ч болоогүй япон хэл үзээд нэг жил ч болоогүй шахам байхдаа багшийнхаа бичсэн “То ван, түүний сургааль” гэсэн онолын өгүүлэлийг монгол хэлрүү буулгах гэж нухаж суусаар дуусгаж, Дорно дахины судлал сэтгүүлд хэвлүүлэх санаатай Онүки багштайгаа хамт С.Лувсанвандан гуайнд очин танилцуулж байсан болон, Их сургуулийн гадаад багш нар, оюутнуудын зуны аялал, судалгаанд багшийнхаа орчуулагч нэрээр, бүх зардлаа даалган Өвөрхангай, Архангайгаар явж байсан зэргээ бодоход зоригтой ч байсан юм шиг, тэнэг ч байсан юм шиг санагддаг юм. МУИС-ийн дөрөвдүгээр ангид орох жил буюу 1977 оны хавар Гадаад явдлын Яаманд дадлага хийж байтал Говь-алтай аймгийн арван жилийн сургуулийн аравдугаар ангийг хамт төгссөн, тэр үед ХХҮЯ-ны орлогч сайд асан Г.Дүгэрсүрэн маань Япон руу явах гээд Гадаад яаманд ажил хөөцөлдөж явахад нь тааралдаж, дараа жилээс Японы оролцоотойгоор ноолуур боловсруулах үйлдвэр байгуулах тухай сонсож, “Чи япон хэлний анги төгсөх юм бол манай яаманд ирж, энэ үйлдвэрт орчуулагчаар ажиллаач” гэсэн ам урилга авснаар Монголын хүнд, хөнгөн, хүнсний үйлдвэр, бизнес, эрүүл ахуй, спорт, урлаг, аялал жуулчлал, байгаль орчины судалгаа, уул уурхай зэрэг бүхий л салбаруудад хэлмэрч, орчуулагч хийх ажил амьдралын зам минь нээгдсэн юм.

Японы техник-технологи, хөрөнгө оруулалтаар байгуулж эхэлсэн ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах “Говь” үйлдвэрт орчуулагчаар ажиллаж байгаад Осакагийн гадаад хэлний дээд сургуульд оюутан солилцооны шугамаар судлаач оюутнаар суралцах шалгалтанд тэнцэж 1980 оны 10-р сарын 9-нөөс нэг жил хагас суралцах сайхан завшаан тохиож, Улаанбаатар-Москва-Токио-Осака гэсэн маршрутаар нисэн очиж Осакагийн баруун хойт зүгт ойн захад орших Аомаданид амьдарсан юм. Энэ хугацаанд олон сайхан япон найз нөхөдтэй болж, хичээлийн танхимд сурахаасаа илүү найз нөхөдтэйгөө ууж идэнгээ, аялаж зугаалангаа японыг таньж мэдсэн минь миний ололт байсан юм шиг санагддаг юм.

Сар бүрийн лхагва гаригт болдог байсан Осакагийн “Монгол судлалын дугуйлан”-д оролцож сонирхолтой олон илтгэл, судалгааг сонсдог байсан боловч ямар нэгэн үнэлэлт дүгнэлт өгч чаддаггүй байсан нь миний япон хэлний мэдлэг, монгол судлалын цар хүрээ өчүүхэн байснаас болсон байх гэж бодохоор одоо харамсах сэтгэл төрдөг юм. Энэ дугуйланд оролцсоны хүчинд あわじ村グループの “Сончө” (村長) Акаиши болон Ашимото, Үэно нартайгаа танилцан сайхан нөхөрлөж, гэр орноор нь орж гарч, Тоттори хүртэл хамтдаа аялаж, Ватанабэ, Ёшимото, Кагава, Шибаяма, Мураи зэрэг олон найз нөхдүүдтэйгээ амралт зугаалганд явж наргин цэнгэж байсан, Тоёонакад байдаг байсан Онүки багшийн гэрт олон

удаа өнжин хонон саатдаг байсан, Аважи өртөөний ард байх Акаишигийн гэрт очин нурж унасан олон номыг нь зайчлан суух зай гарган саатаж, хэдүүлээ нийтийн халуун усанд орж (Мөрөн дээрээ алчуур тохчихоод Аважи мураад алхаж байхдаа өөрийгөө япон хүн болчихсон мэт санаж байж билээ), ганц нэг шар айраг уунгаа элдвийг чөлөөтэй ярилцдаг байсан маань миний хувьд хичээлийн танхимд биш жинхэнэ амьдрал дунд, эгэл борчуудын хороололд очиж, эгэл жирийн япон айлд хонон өнжиж явсан минь япон орон, япончуудыг таньж мэдэхэд хамгийн их ач тусаа өгсөн гэж боддог юм.

1980 онд очсон Мажигийн Энхсайхан бид хоёр Японд судлаач оюутнаар суралцсан 5,6 дахь оюутан байсан бөгөөд миний өмнө очсон бүх оюутан эхний хагас жилээ Осакад суралцаад дараа нь Токиогийн гадаад хэлний сургуульд шилжин суралцаж төгөсдөг байсан боловч яагаад ч юм би анх удаа Осакагаас яваагүй бөгөөд төгсөөд нутаг руугаа буцах үедээ Хасуми багштай уулзах үед “Онүки чамайг Токио руу явуулсангүй юу” гэх маягаар үг хаяж байснаас үзэхэд Онүки багш маань намайг Осакад авч үлдсэн юм байх гэж бодсон. Японд нэг жил хагас суралцах хугацаандаа Хирошима, Нара, Кёото, Мэйжи мура, Мие мужийн Това хот, Вакаяма мужийн Кижима, Наганогийн Ямамото хот, Хиогогийн Химэжи, Айчи мужийн Тоёото хот, Окаяма мужийн Ибараги хот, Тоттори муж зэрэг 20-иод хот, арав гаруй мужаар аялан түүх, соёлтой танилцсан тухайгаа Монголын элчин сайдын яаманд өгсөн тайландаа бичсэнээсээ болж “Хичээл хийлгүй тэнэсээр байгаад буцсан” гэдэг зэмлэл хүртэж байсан юм. Энэ бүхэн миний япон хэлний мэдлэг дээшлэхэд, япон орон, япончуудыг таньж мэдэхэд нэмэр болсон юм.

Эр үеэс 30 гаруй жилийн дараа Шига мужийн их сургуулийн судалгааны багийнхантай “Өндөр дов” хэмээх жуулчны бааз руу явах гээд “Улаанбаатар” зочид буудлын өмнө нөхөдөө хүлээж байтал бидний өмнө зогсож байсан машины дэргэд зүс таних нэгэн япон хүн зогсож байсан бөгөөд өөрийн мэдэлгүй хоёр талаасаа ойртон уулзаад, “もしかしたら、あなたは村井さん、(バットさん) じゃないか?” гэцгээн бурханы зураглалаар дахин уулзсанаас хойш бидний нөхөрлөл Монголд дахин үргэлжлээд арваад жил болж байна. Энэ хооронд бид байнга холбоотой байж, хамтран ажилласны хүчинд “Япон хэлний сургалтын тахим”(日本語の学習室, 2006) сургалтын гарын авлага, “Япон дахь Монголын түүх судлалын тухайд” эрдэм шинжилгээний өгүүлэл (Чингис хаан ба Хэнтий аймгийн хөгжил дэвшил сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2007), “Японыг ойлгож монголд буулгах нь”(和文解釈・モンゴル編, 2008, М.Мураи-тай хамтран), “Япон хэлний дүрэм”(日本語の文, 2008, охин Б.Болормаатай хамтран) сурах бичиг, “Зүүн Азийн нүүдлийн шувууны бүс дэх усны ургамалын төрөл зүйл, тархацын судалгаа”(東アジアにおける水鳥のフラウエイ中継湿地での水草生物相の分布と遺伝的多様性)(2008, Японы Шигагийн их сургуулийн эрдэмтэдийн судалгааны группын хамтрагчаар), “Япон хэлэн дэх катакана үгийн толь бичиг”(カタカナ語辞典, 2010. М.Мураи-тай хамтран), “Япон хэлний өгүүлбэрзүйн толь бичиг”(日本語の文型辞典, 2011), “Япон-монгол хэлц үгийн толь”(日モ諺辞典, 2012) гэх мэт

бүтээлүүд хэвлэн нийтлүүлээд байна.

Осакагийн “Монгол судлалын дугуйлан”-гийн эрт эдүгээгүйн, таних танихгүй бүх судлаач та бүхэндээ эрдэм судлалын их амжилт хүсэн ерөөхийн ялдамд ойрын ирээдүйд нэг удаагийнхаа 研究会を 旅行をかねてモンゴルでどうですか гэсэн санал тавьж байгааг минь болгоон соёрхоно уу.

Та бүхнийг хүндэтгэн ёсолсон Раднаагийн Баттогтох.

2011.12.16.

(ラドナーギーン バットトグトフ)